



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН АЛБАН ДААЛГАВАР

2025 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан
сэргийлэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр авч
хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Ой, хээрийн түймэр, шар усны үер, үер зэрэг байгаль цаг уурын гаралтай аюулт гамшигт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, мэргэжлийн байгууллагуудын бэлэн байдлыг хангах, орон нутгийн болон улсын хэмжээнд хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, зөвлөмж, сэрэмжлүүлэг мэдээ, мэдээллийг иргэд олон нийтэд хүргэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27¹.1.4 дэх заалтыг үндэслэн ДААЛГАХ нь:

Нэг. Улсын онцгой комиссын гишүүд, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт:

1.1. Ой, хээрийн гал түймрийн эрсдэлийг урьдчилан бодитоор үнэлэх, цагийн байдал, орон нутгийн онцлогт тулгуурласан хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх, шаардлагатай төсөв, хөрөнгийг нэмэгдүүлэх,

1.2. Байгаль, цаг уурын нөхцөл, орон нутгийн онцлог, гамшигт аюулт үзэгдлийн төрөл тус бүрт тохируулан урьдчилан сэргийлэх шийдлүүдийг аймаг, сум, багийн хэмжээнд нарийвчлан гаргаж хэрэгжүүлэх, холбогдох төсөв хөрөнгийг шийдвэрлэх,

1.3. Ой, хээрийн түймэр гарахад нөлөөлж буй шалтгаан нөхцөлийг тогтоох, эзэн холбогдогчийг илрүүлэх, хуульд заасан хариуцлага оногдуулах, нөхөн төлбөрийг төлүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааг эрчимжүүлэх,

1.4. Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх орон нутгийн захиргаа, олон нийтийн хяналтыг эрчимжүүлэх,

1.5. Ой, хээрийн гал түймэртэй тэмцэх дрон, хиймэл дагуулын тандалт, мэдрэгч, дохиолол, интернет холбоо зэрэг дэвшилтэт технологийг орон нутгийн түвшинд нэвтрүүлэх, шаардлагатай хүний нөөцийг бэлтгэх,

1.6. Гал унтраах мэргэжлийн анги, сайн дурын хэсгийн техник, багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах, тоо хэмжээг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдлын чиглэлээр тогтмол сургалт зохион байгуулах,

1.7. Ой, хээрийн гал түймрийг илрүүлэх ухаалаг хяналтын систем нэвтрүүлэх чиглэлээр тогтмол судалгаа хийж, нэвтрүүлэх, эрсдэлтэй цэгүүдэд тавих хяналтыг эрчимжүүлэх,

1.8. Ой, хээрийн гал түймэртэй тэмцэх төсөв хөрөнгийг нэмэгдүүлэх, олон улсын санхүүжилт, хамтын ажиллагааны төсөл хөтөлбөрүүдийг бүрэн ашиглах боломжийг бүрдүүлэх,

1.9. Орон нутгийн түвшинд мэргэжлийн байгууллага, орон нутгийн захиргааны байгууллагын ажлын уялдаа холбоог сайжруулах,

1.10. Осол, гал түймэр, гамшгийн үед ажиллах мэргэжлийн анги, сайн дурын хэсэг, орон нутгийн иргэдэд тогтмол сургалт, дадлага зохион байгуулах,

1.11. Үерийн далан, суваг, шуудууны төлөвлөлт, ашиглалтад хяналт тавьж, шаардлагатай газруудад засвар, сэргээн босголтын ажлыг цаг алдалгүй хийх чиглэлээр холбогдох мэргэжлийн байгууллагууд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар хамтран ажиллах,

1.12. Усны урсац газар, голын гольдрол газруудад хяналт шалгалт хийж, тухайн газруудад иргэд суурьшсан эсэхийг тодруулж, үерийн эрсдэлийг тодорхойлох, иргэдэд мэдээллийг шуурхай хүргэх ажлыг цаг алдалгүй зохион байгуулж, эрсдэл бүхий газраас иргэдийг нүүлгэн шилжүүлэх ажлыг аймаг, нийслэлийн Засаг дарга болон бусад холбогдох мэргэжлийн байгууллагууд хамтран зохион байгуулах,

1.13. Үерийн гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг нийтэд хүргэх, аюулыг амжиж анхааруулах системийг хөгжүүлэн сайжруулж, хамрах хүрээг өргөтгөх ажлыг шуурхай зохион байгуулах,

1.14. Болзошгүй үерийн улмаас эвдрэл гэмтэл үүсч болзошгүй авто зам, замын байгууламж, төмөр замын дагуу үерийн эрсдэлийн үнэлгээг хийж, хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулж, засвар үйлчилгээг төлөвлөгөөний дагуу чанартай хийж, бүх чиглэлд тээврийн үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлэх,

1.15. Үерийн улмаас эвдэрч, нурсан зам, гүүрийг богино хугацаанд сэргээн засварлахад шаардлагатай эд материал, тоног төхөөрөмжийн нөөцийг бүрдүүлж, хүн хүч, техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг харьяа байгууллага, салбар нэгжүүдийн хэмжээнд хангуулах,

Хоёр. Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуян болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Онцгой комиссын дарга нарт:

2.1. Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийт, аж ахуйн нэгж байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, тогтмол сургалт зохион байгуулах,

2.2. Аливаа гамшиг, гал түймрийн эрсдэлийг мэдээлэх гар утасны аппликэйшн, мэдээллийн сүлжээг улсын хэмжээнд дахин үнэлэх, шаардлагатай арга хэмжээг авах,

2.3. Үерийн гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэх, аюулыг амжиж анхааруулах системийг хөгжүүлэн сайжруулж, хамрах хүрээг өргөтгөх ажлыг шуурхай зохион байгуулах,

2.4. Цаг агаарын аюулт гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх ажлыг өргөн хүрээтэйгээр бүх төрлийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр шуурхай тогтмол хүргэх, мэргэжлийн байгууллага хоорондын мэдээлэл дамжуулах системийг сайжруулах,

Улсын онцгой комиссын гишүүд аймаг, нийслэлийн Засаг дарга нар албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, хийж гүйцэтгэсэн ажлын мэдээ тайланг нэгтгэн Улсын онцгой комиссын Ажлын албанд 14 хоног тутам uok@nema.gov цахим хаягаар болон албан бичгээр ирүүлэх.

ДАРГА



С.АМАРСАЙХАН